

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр
“Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн” НҮТББ-ын
судлаач, хуульч М.Маралмаа, Б.Мягмарсүрэн нар гүйцэтгэв.

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Асуудлын танилцуулга

	Анхдагч	Шинэчилсэн найруулга	Нэмэлт, өөрчлөлт	Хүчингүй болсонд тооцох	УИХ-ын тогтоол	Нийт
2026			2		2	4
2025*			12	1	6	19
2024			22		7	29
2023*	4		107	3	11	125
2022*	4		37	1	6	48
2021*	1		9	2	5	17

ХТТХ-ийн 29.5

“[тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол]-ийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана”

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдэл

ЗГ-аас 2026 оны төсвийн тухай хуулийг өргөн мэдүүлэхдээ дараах баримт бичгийн бүрдэлтэйгээр өргөн мэдүүлсэн.

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлал;
2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулга (товч хувилбартай);
3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт - Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт;
4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт - Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт;
5. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага

Үзэл баримтлал	Үзэл баримтлалд (i) үндэслэл, шаардлага, (ii) зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, (iii) үүсэх үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал, (iv) бусад хууль тогтоомжийн уялдааны талаар тусгасан байх боловч дагалдуулаад буй 2 хуулийн төсөл, УИХ-ын 2 тогтоолын төслийн хэрэгцээ, шаардлага, үр дагаврын талаар үзэл баримтлалд дурдаагүй.
Танилцуулга	Хуулийн төсөл нь дэлгэрэнгүй болон товч танилцуулгатай бөгөөд дэлгэрэнгүй танилцуулга нь Төсвийн тухай хуулийн 32.2-т заасан шаардлагыг хангаж, жагсаасан 21 агуулгыг бүхэлд нь тусгажээ. Мөн тус танилцуулгад дагалдуулан өргөн мэдүүлсэн 2 хуулийн төсөл, УИХ-ын 2 тогтоолын төслийн 2026 оны улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тусгасан байхаас гадна дагалдах хууль тогтоомжийн төсөл бүрийн эхэнд товч үндэслэлийг дурдсан танилцуулгыг хавсаргасан байна.
Олон нийтийн хэлэлцүүлэг	Төсвийн тухай хуулийн 6.5 - төсвийн ил тод байдлын зарчим 28 ¹ - олон нийтийн оролцоо • E-Mongolia - 188,016 иргэн (насанд хүрсэн иргэдийн 8.2 хувь) • Танхимаар нийт 1390 иргэн • Бусад хэлбэрээр (вэбсайт болон утсаар) 238,388 иргэн Энэхүү олон нийтийн санал асуулга нь боловсруулагдсан хуулийн төсөл дээр бус төсвийн зарлагын зориулалт дээр олон нийтийн саналыг авах агуулгаар бэлтгэсэн асуултад суурилж, үр дүнг танилцуулгад дурдсан байх бөгөөд санал асуулгад дагалдах хууль тогтоомжтой холбоотой хэсэг байхгүй байв.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн товч агуулга

2026 оны татварын жилд	Сарын 1,000,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 50 хувийг, 1,000,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварын 20 хувийг;
2027 оны татварын жилд	Сарын 0-500,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 100 хувийг, 500,001-1,000,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 50 хувийг, 1,000,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварын 20 хувийг;

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5

... төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана”.



2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга болон НӨАТтХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгад төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлжээ.

“Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, орлогын тэгш бус байдал буурч, татварын хамрагдалт нэмэгдэх ач холбогдолтой бөгөөд... нийт иргэдийн 75 хүртэл хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас 50-100 хувь хөнгөлөгдөх ба энэ нь 2026 оны төсөвт 375 орчим тэрбум төгрөгөөр нөлөөлөхөөр байна.”

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 1/3

Ерөнхий утга	Өөрчлөлтийн агуулга
Аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх түншлэлийн төсөлтэй холбоотой	Нийслэл болон улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100,000 ба түүнээс дээш хүн амтай аймаг л тодорхой салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлэх боломжтой байсныг, Бүх аймаг болон нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлж болохоор; Аймаг, нийслэл зөвхөн тодорхой салбарт түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой байсныг, Аймаг, нийслэл бүх төрлийн салбарт түншлэлийн төсөл хэрэгжүүлж болохоор;
Төрийн үйлчилгээ үзүүлэх түншлэлийн төсөлтэй холбоотой	Нийтийн зориулалттай дэд бүтцийн төсөл эсхүл төрийн үйлчилгээний салбарын төсөл эсэхээс үл хамааран ТЭЗҮ болон бусад судалгаа хийгдсэн байх шаардлага тавьдаг байсныг, Төрийн үйлчилгээ үзүүлэх төслийн хувьд ТЭЗҮ шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийхгүй байж болохоор;
Хувийн хэвшлийн түншлэгч сонгон шалгаруулахтай холбоотой	Хувийн хэвшлийн түншлэгч сонгон шалгаруулалтыг урьдчилсан болон уралдаант гэх хоёр үе шаттай байсныг, Сонгон шалгаруулалтын баримт бичигт тулгуурлан нэг үе шаттай сонгон шалгаруулахаар;

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2/3

Ерөнхий утга	Өөрчлөлтийн агуулга
Процесс болон түншлэлийн төсөлд тавигдах шаардлага	Түншлэлийн төсөл шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахаар; Түншлэлийн төсөл нь хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;
Бүэн эрхтэй холбоотой	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүх төрлийн түншлэлийн төсөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгодог байсныг; Зардлыг нь хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлэх түншлэлийн төсөлд зөвхөн санал дүгнэлт өгөх, харин түншлэлийн төслийн зардлын улсын төсвөөс бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлэх төслийн хувьд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгохоор; Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл өгөх, зөвшөөрөхгүй байх эрхтэй байсныг; Гэрээ байгуулах, гэрээний нэмэлт, өөрчлөлттэй холбоотой санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх болгох.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3/3

ХТТХ-ийн 29.5

“[тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол]-ийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана”

Төлөвлөгөө: 120

2026 оны төсөвт тусгасан – 51

Санхүүжилтийн тодорхойгүй – 69

- хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах,
- төсвийн дарамт бууруулах эерэг нөлөөтэй.

Тооцоолол
тусгаагүй

Үр дагавар

- Аудитын дүгнэлт
- Чанаргүй төслүүд
- Үйлчилгээ үзүүлэх түншлэлийн төсөл судалгаагүй хэрэгжих

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ 1/2

Төслийн товч агуулга

Дотоод үнэт цаас	2026 онд 561.2 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас гаргах эрхийг ЗГ-т олгох;
Гадаад үнэт цаас	2026 онд 1.0 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас гаргах эрхийг ЗГ-т олгох;

Өрийн удирдлагын тухай хууль


Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 8 дугаар зүйлийн 8.1.2-т тус тус зааснаар тухайн төсвийн жилд ЗГ-ын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг төсвийн хамт өргөн мэдүүлнэ.



2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад ЗГ-ын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон.

Засгийн газраас 2020 онд гаргасан “Номад” бондын 174.3 сая ам.доллар буюу 656.6 тэрбум төгрөгийн төлбөр 2026 оны 04 сарын 07-ны өдөр төлөгдөх хуваарьтай, 2026-2028 оны хооронд нийт 1,130.1 сая ам.долларын төлбөр хугацаа тулсан байна. Энэ нь төрийн сангийн мөнгөн хөрөнгө болон гадаад валютын албан нөөц, төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй байна.

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төсөл 2/2



Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл 1/2

Төслийн товч агуулга

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд

Тавантолгойн бүлэг ордын ашиглаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах

Орд ашиглалтыг сайжруулах талаар хөрөнгө оруулагч хуулийн этгээдүүдтэй хууль тогтоомжийн дагуу хэлцэл хийх

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5

... төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана”.



2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад тус УИХ-ын тогтоолын төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд биржийн томоохон дүнтэй арилжааг зохион байгуулах нь зүйтэй. Тухайлбал, 1.0 тэрбум ам.долларын үнийн дүнтэй 3-5 удаагийн нүүрсний том арилжааг амжилттай зохион байгуулсан тохиолдолд дэнчин болон эхний төлбөрийн орлогоор 250-350 орчим тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлэх боломжтой байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл 1/2

01

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтэд:

- ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасантай нийцүүлээгүй
- 2026 оны төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг тодорхой тусгаагүй
- ХТтХ-ийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт буюу шийдвэрлэх асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар томъёолж бичих шаардлагыг мөн хангаагүй

02

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон байдлаас үзвэл:

- Таамагласан шинжтэй
- Хэрэгжих боломжтой эсэх нь эргэлзээтэй ерөнхий асуудлыг тусгасан
- ХТтХ-д заасан төсвийн дагалдах хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй

Суурь асуудлыг шийдвэрлэх боломж

Дагалдах хууль тогтоомж

29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага
29.3. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.

Ж.нь. Зөрчлийн тухай хууль
Нэг хуулиас хамааралтайгаар бусад хуульд өөрчлөлт орох тохиолдол

Хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомж

14 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах
14.4. Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.

Ж.нь. Боловсролын хууль
Хамтдаа өргөн барьж, батлагдсанаар эрх зүйн үр нөлөө нь бүрэн хэрэгжих

Дүгнэлт

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ХТтХ-ийн 29.3, 29.5-д нийцсэн. Гэхдээ цаашид татвартай холбоотой асуудлыг төсвийн тухай хууль дагалдуулан батлах нь хэр зохимжтой талаар нэгдсэн байр сууринд хүрэх.
2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь ХТтХ-ийн 29.3-т нийцсэн боловч 29.5-д заасан шаардлагыг хэлбэрийн төдий хангасан. Хэдийгээр төслийн зохицуулалтууд процессын саад бэрхшээлийг бууруулахад чиглэсэн (зорилготой) байх боловч чухал өөрчлөлтүүдийг тухайлсан судалгаа, шинжилгээ, харьцуулалтгүйгээр оруулахаар байгаа нь сөрөг үр дагавруудыг үүсгэх боломжтой.
3. Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төсөл нь холбогдох хуульд нийцсэн.
4. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл нь холбогдох тооцоолол тодорхойгүйн зэрэгцээ ХТтХ-ийн 36.4-т заасан шийдвэрлэх асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар томъёолж бичих, 36.3-т заасан УИХ-ын тогтоолын төслийн үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх шаардлагуудыг хангаагүй.